


Батлав

СҮХБААТАР НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН

ДАРГА



Б.ЭНХТӨР



УХААЛАГ ЦАХИМ АРХИВЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ДАГАЛДАХ
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 он

УХААЛАГ ЦАХИМ АРХИВЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ДАГАЛДАХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дагалдах үйлчилгээний нэр: Ухаалаг цахим архивын тоног төхөөрөмж болон дагалдах үйлчилгээ худалдан (*Архивийн өгөгдөл хайлт, мэдээллийн бүрдүүлэлт, бүртгэл хяналт, тооллого хийх цогц систем*)

Захиалагч байгууллага: Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар

Даалгаврын хугацаа: 2 сар

1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Нийтийн мэдээллийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг үндэслэн төрийн байгууллагын үйл ажиллагаанд баримт бичгийн удирдлагын цахим тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар нь архивын үйл ажиллагааг цахимжуулж, хялбаршуулах мөн төвлөрсөн цахим лавлагааны систем нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Архивт байрлах олон жилийн туршид хуримтлагдсан цаасан архивын материалууд дундаас иргэдийн хүсэлтийн дагуу лавлагаа хийх, хувийн хэрэг хайж олох нь маш их цаг алдах улмаар өдөр тутмын үйл ажиллагаанд доголдол учруулах нь өнөөдрийн байдлаар нийтлэг үзэгдэл болоод байна. Тиймээс, бидэнд радио долгионы тусламжтайгаар бичиг баримт хайж олох, материалуудын бүрэн бүтэн байдлыг хангаж хялбараар тооллого хийх мөн эдгээр материалуудын цахим хувилбараас лавлагаа хийх боломжтой цогц шийдэл хэрэгтэй байна. Энэхүү систем нь түргэн шуурхай, зардал багатай, найдвартайгаар ажиллагаатай бөгөөд RFID технологи дээр суурилсан үүлэн систем байх ёстой.

Архивын үйл ажиллагааг цогцоор нь хялбар удирдахад туслах программ хангамжийн шийдлийг хайж байна. Тус газар нь одоогоор санхүүгийн мэдээллээ удирдахдаа гар ажиллагаатай процессуудыг ашиглаж байгаа бөгөөд энэ нь алдаа, саатал гарах, цаг хугацаа маш ихээр алдахад хүргэдэг. Програм хангамжийн шийдэл нь архивын удирдлагын үйл явцыг оновчтой болгож, ард иргэдэд болон байгууллагуудад үнэн зөв, цаг алдалгүй мэдээллээр хангах чадвартай байх ёстой.

2. СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Архивын өгөгдөл хайлт, мэдээлэл бүрдүүлэлт, бүртгэл хяналт, тооллого хийх зэрэг үйл ажиллагаа бүрийг процесс зураглалын дагуу бүрэн гүйцэтгэх, дээрх үйлдэлтэй холбоотой системийн дагалдах нэмэлт шаардлагуудыг хангах мөн процессын алхам бүр дэх өгөгдлийн менежментийг хийдэг байна.

Систем нь орчин үеийн радио давтамжийг таних технологи дээр суурилсан байх шаардлагатай бөгөөд программ хангамж нийлүүлэгч байгууллага нь уншигч төхөөрөмжүүдийн албан ёсны Монголд дахь төлөөлөгчийн эрхтэй байна.

Систем нь олон байгууллагын бүтэцтэй мөн нийгмийн даатгалын шинэ системтэй холбогдон ажиллах бүрэн боломжтой байна.

Систем нь олон улсын стандартад нийцсэн бүхий л нууцлал болон хамгаалалтын технологийг ашигласан байх.

ҮНДСЭН ШААРДЛАГА:

2.1. Ерөнхий шаардлага:

2.1.1. **Хэрэглэгчийн баталгаажуулалт ба зөвшөөрөл:** Програм хангамж нь хэрэглэгчдийг бүртгэх шинээр, бүртгэлээс хасах, нууц үг сэргээх зэрэг хэрэглэгчийн удирдлагын модультай байна.

2.1.2. **Цахим бичиг баримт бүртгэл, ангилал:** Програм хангамж нь архивын бичиг баримт бүртгэх, цахим хувилбаруудыг файлаар хадгалах, мөн баримтуудыг ангилах, бичиг баримтын төрөл бүрийн мэдээллүүдийг админ эрхтэй хэрэглэгч динамикаар удирдах боломжтой байх ёстой..

2.1.3. **Цахим файл хайлт:** Програм хангамж нь цахим бичиг баримтуудыг түлхүүр үгээр, огноогоор, байршлаар, ангиллаар гэх мэт төрөл бүрийн өгөгдөл хайлтыг хийх, мэдээллийн бүрдүүлэлт хийх модультай байх ёстой.

2.1.4. **Цаасан баримт хайлт:** Програм хангамж нь RFID уншигчын тусламжтайгаар архивын бичиг баримтууд дундаас хялбархан бөгөөд богино хугацаанд ойртох тусам мэдэгдэх зарчимаар хүссэн баримт бичгээ олох шийдэлтэй байна.

2.1.5. **Тооллого ба залруулга:** Програм хангамж нь архивт байрлах 50,000 гаруй баримт бичгийг маш богино хугацаанд буюу нэг цагын дотор тооллогын ажлын бүрэн гүйцэтгэхээс гадна дутсан эсхүл илүү гарсан бүртгэлийн залруулгын ажлын хамтаар хийх чадвартай байх шаардлагатай.

2.1.6. **RFID шошгоны холболт ба менежмент:** Програм хангамж нь RFID хэвлэгч төхөөрөмж болон RFID уншигч төхөөрөмжүүдийн тусламжтайгаар бичиг баримтийн системийн кодыг RFID шошго дээрх тусгай кодтой уялдуулж бүртгэлийг хялбархан хийдэг байх. Үүнээс гадна эдгээр бүртгэлийг алдаа гарсан тохиолдолд засаж янзлах, устгах боломжтой байх.

2.1.7. **Системийн удирдлага:** Програм хангамж нь байгууллагын тодорхой хэрэгцээнд нийцүүлэн тохируулгыг хийх боломжтой байх ёстой бөгөөд админ эрхтэй хэрэглэгч нь талбарууд өөрчлөх, шинэ хэрэглэгч нэмэх, хасах, нууц үг, и-мэйл солих, хяналтын самбар үүсгэх зэрэг шаардлагын дагуу бусад төрлийн өөрчлөлтийг хийх боломжтой байх ёстой.

2.1.8. **Хэрэглэгчдэд ээлтэй байдал:** Програм хангамж нь хэрэглэгчдэд ээлтэй байх ёстой бөгөөд хэрэглэгчдэд хялбар чиглүүлэх, даалгавар гүйцэтгэх боломжийг олгодог зөн совинтой интерфэйстэй байх ёстой.

2.1.9. **Сургалт, дэмжлэг:** Програм хангамжийн үйлчилгээ үзүүлэгч нь байгууллагын ажилтнуудад программ хангамжийг үр дүнтэй ашиглах

боломжийг хангахын тулд цогц сургалт, дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлэх ёстой.

2.1.10. **Дагаж мөрдөх:** Програм хангамж нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд баримт бичгийн удирдлагын дүрэм журам, бүртгэлийн стандартад нийцсэн байх ёстой.

2.1.11. **Аудитын лог:** Программ хангамж нь хэрэглэгчийн үйлдэл, архивийн өгөгдөлд хийсэн өөрчлөлт зэрэг бүх архивийн шилжилт хөдөлгөөн бүрийн иж бүрэн хөтлөх ёстой.

2.1.12. **Өргөтгөх чадвар:** Програм хангамж нь байгууллагын ирээдүйн өсөлт, өргөжилтийг хангахын тулд хэвтээ ба босоо өргөтгөх (horizontal and vertical scaling) боломжтой байх ёстой.

2.1.13. **Гүйцэтгэл:** Програм хангамж нь их хэмжээний цахим баримт бичгийн мэдээлэлтэй ажиллах чадвартай байх ба бодит цагийн горимоор тайлагнах чадварыг хангасан байх ёстой.

2.1.14. **Мобайл хандалт:** Програм хангамж нь хөдөлгөөнт төхөөрөмжөөр дамжуулан хандах боломжтой байх ёстой бөгөөд ингэснээр хэрэглэгчдэд архивийн санд хялбараар нэвтрэх боломжтой байх ёстой.

2.1.15. **Интеграцчилал:** Програм хангамж нь Core system, ERP, ХУР, ДАН зэрэг төрийн байгууллагын ашигладаг бусад програм хангамжийн системүүдтэй нэгдэх чадвартай байх ёстой.

2.1.16. **Мэдээллийг нөөцлөх, сэргээх:** Програм хангамж нь системийн доголдол, гамшгийн үед өгөгдөл алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд найдвартай өгөгдлийг нөөцлөх, сэргээх боломжуудтай байх ёстой.

2.1.17. **Аюулгүй байдал:** Програм хангамж нь архивлагдаж буй бичиг баримт доторх эмзэг мэдээллийг хамгаалахын тулд дотоод сүлжээний хязгаарлалт, хандалтын лог хяналт, өгөгдлийн шифрлэлт зэрэг найдвартай хамгаалалтын тусгай функцуудтай байх ёстой.

2.1.18. **Шошго ба төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагаа:** Програм хангамж нь RFID шошго болон RFID уншигч төхөөрөмжүүдийн нийлүүлэгч нь найдвартай ажиллагааг хангаж ажиллах ёстой.

2.1.19. **Бичиг баримт цахимжуулалт:** Тендерт оролцогч нь архивын бичиг баримтуудыг цахимжуулах тусгай баг гарган ажиллана, мөн түүнчлэн 2 ширхэг шаардлага хангахуйц сканнер төхөөрөмж Захиалагчид нийлүүлнэ.

2.2. Функциональ шаардлага:

- **Нэвтрэх ба хэрэглэгчийн үүрэг**
 - Хэрэглэгч нэвтрэх: Хэрэглэгчид и-мэйлээрээ дамжуулан баталгаажуулалт хийж аюулгүй нэвтэрдэг байх ёстой.
 - Хэрэглэгчийн үүрэг: Систем нь администратор, архивч, стандарт хэрэглэгч гэх мэт өөр өөр хэрэглэгчийн үүргийг дэмжих бөгөөд тус бүр нь тусгай зөвшөөрөлтэй байна.

- Хандалтын хяналт: Хэрэглэгчид зөвхөн өөрт оногдсон үүрэгт тулгуурлан функцүүдэд хандах эрхтэй байх.
- **Бичиг баримт бүртгэл, ангилал**
 - Бичиг баримт бүртгэл: Хэрэглэгчид гарчиг, тайлбар, архивын огноо зэрэг холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг системд шинээр бүртгүүлэх боломжтой байх.
 - Ангилал: Урьдчилан тодорхойлсон категори дээр үндэслэн баримт бичигийг динамикаар ангилах боломжтой байх.
- **RFID шошгын менежмент**
 - Шошго холболт: RFID кодууд нь бүртгэлийн явцад архивлагдсан баримт бичигүүдтэй нэг бүрчлэн холбогдсон байх болно.
 - Шошгоны кодчилал: Програм хангамж нь RFID кодуудыг дарааллын дагуу, үнэн зөв, найдвартай кодлосон байх ёстой. Админ хэрэглэгч нь бүтэн CRUD эрхтэй байх.
 - Шошго скан хийх: Хэрэглэгчид холбогдох баримт бичигийн талаарх мэдээллийг авахын тулд RFID хаягуудыг сканнердах боломжтой байх ёстой.
- **Цахим болон цаасан материал хайлт**
 - Түлхүүр үг хайх: Хэрэглэгчид түлхүүр үг, гарчиг эсвэл бусад шинж чанарууд дээр үндэслэн зүйлсийг хайж болно. Ингэхдээ хайлтын илэрц доторх дэлгэрэнгүй мэдээлэл дотор тухайн баримттай холбоотой бүхийл цахим файлуудыг агуулсан байна. Цахим файлыг зөвхөн харах боломжтой, устгах, засвар хийх боломжгүй онлайн PDF файл уншигчтай байх.
 - Нарийвчилсан хайлт: Ангилал, огнооны хүрээ, байршил зэрэг дэвшилтэт хайлтын шүүлтүүрүүд бэлэн байх ёстой.
 - Цаасан материал хайлт: Систем нь өгөгдсөн баримтын кодын дагуу радарын системтэй төстэй байдлаар дуут дохиогоор хайлт хийж баримт бичгийг хялбар бөгөөд хурдан олох функцтэй байх зайлшгүй шаардлагатай.
- **Системийн удирдлага**
 - Хэрэглэгчийн удирдлага: Администраторууд хэрэглэгчийн бүртгэл нэмэх, өөрчлөх, устгах боломжтой.
 - Тохиргоо: Системийн тохиргооны тохиргоог админууд динамикаар тохируулах эрх байна.
 - Аудитын логоуд: Аудитын зорилгоор хэрэглэгчийн үйл ажиллагаа болон системийн үйл явдлын бүртгэлийг бүрэн хөтөлнө.

НЭМЭЛТ ШААРДЛАГА:

2.3. Нэмэлт программын шаардлага:

- Автоматжуулсан тайлангууд хэрэглэгч боловсруулах чадвартай байх (Report Builder)
- Гар утасны хувилбар (Native аппликейшн хувилбар)

- Гар утсанаас хэрэглэгч хандан ашиглах боломжтой байх.
- Үйл ажиллагааны процессуудыг динамкаар өөрчилж болдог байх.
- Процессын зураглал болон гүйцэтгэгчийг тохируулж болдог байх. Өөрөөр хэлбэл Процессын автоматжуулагч функтэй байх.
- Ямарваа нэгэн үйлдэл хийх болон үүнтэй холбогдох ажлын даалгавар форм/маягтыг динамикаар өөрчилж засвар хийж болдог байх.
- Бусад хөгжүүлэлт
 - Аудитийн лог гардаг байх
 - Системийн лог гардаг байх

2.4. Мэдэгдлийн систем

- Процесс болон бусад бүх үйлдэл дээр мэдэгдэл явуулна.
- Хэрэглэгч бүрд холбогдох шаардлагын дагуух чухал мэдэгдлүүд системээр болон и-мэйлээр ирнэ.

2.5. Хэрэглэгчийн профайл удирдлага

- Хэрэглэгч өөрийн нууц үгээ солих боломжтой байна.
- Хэрэглэгч өөрийн ажил үүргээ бусад хэрэглэгчдэд түр шилжүүлэх, жишээлбэл ээлжин амралт авах үед, боломжтой байх. (Delegation authority)
- Аюулгүй байдлын үүднээс нэвтрэх оролдлого бүрийг бүртгэх харах. 5-н удаа нэвтрэх оролдлого буруу хийсэн үед эрхийг хязгаарладаг байх.

2.6. Нууцлалын шаардлага

- Үндсэн фрэймворкийн технологийн дагуу өгөгдлийг хадгалах, харуулах үйлдлийг хийнэ. Шууд баазруу хандах, хадгалах үйлдлийг хориглоно.
- Нууц үгийн шаардлагыг нийтлэг стандартын дагуу том жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт шаардах.
- Вэб системүүдрүү интернетээр халддаг халдлагуудаас сэргийлсэн байна. Жишээ нь: Brute force, Credential stuffing, SQL Injection, Cross-site scripting, Cookie poisoning, Sensitive data disclosure, Session hijacking гэх мэт.

2.7. Програм хангамжийн чанарын шаардлага

- Олон улсад нийтлэг ашиглагдах кодын нэг төрлийн стандартаар кодыг бичигдсэн байна.
- Кодын Unit болон Integration тестүүд хийгдсэн байна.
- Туршилт шалгалт хийж бодит амьдрал дээрх туршилт хийсний дараа төсөл хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр үндсэн серверт байршуулж үйл ажиллагаанд оруулна.
- Системийн код нь хард код (Hard coding) болон Шидэт тоо (Magic Number) зэргийг ашиглахгүй байна. Зайлшгүй шаардлага үүссэн үйд тайлбартай хамт кодчилж болно.

2.8. Хүчин чадлын шаардлага

Систем нь хамгийн багадаа нэгэн зэрэг 1000 хэрэглэгч хандах ачааллыг даах чадвартай байх бөгөөд доор дурдсан техникийн үзүүлэлтээс хэтрэхгүй нөөц ашиглана. Үүнд:

- Хатуу диск: 5000 GB
- Шуурхай санах ой: 16GB
- Төв процессор: 2.5GHz

2.9. Аюулгүй байдлын шаардлага

Аюулгүй байдлын шаардлагад доорх зүйлс хамаарна. Үүнд:

- Хуулбарлах эсвэл устгах үйлдлүүд бүгд Confirmation буюу анхааруулга мэдэгдлийг эрх бүхий хэрэглэгчидэд харуулна.
- Систем нь алдааг хамгийн бага байхаар тест хийгдсэн байна. Хэрэв алдаа гарсан бол шалтгааны маш тодорой лог бичигдсэн байх.
- Системд ашиглагдаж байгаа өгөгдлүүдийн аюулгүй байдлыг хангана.
- Өгөгдөл устгах үйлдлээс аль болох зайлсхийх.
- Системийн хэрэглэгчдийн хийсэн үйлдлүүд лог болон бүртгэгдэх.

3. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Төслийг хэрэгжүүлэх үйл явцын гэрээт хугацаа нь нийт 2 сар байх бөгөөд үндсэн гурван үе шатанд хуваагдана.

3.1. Процессын судалгаа, шинжилгээ

3.2. Нэмэлт хөгжүүлэлт хийх

3.3. Баримт болон шошгонуудын цахим бүртгэл

3.4. Системийг турших, нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах.

3.5. Жигдрүүлэлт, програмчлалын сайжруулалт, ажил хүлээлцэх.

4. ТӨСЛИЙН БАТАЛГААТ ХУГАЦАА

Төслийн баталгаат хугацаа нь гүйцэтгэгчтэй байгуулсан үндсэн гэрээний хугацаа дууссанаас хойш 12 сар байна. Энэ хугацаанд нийт ажлын 20 хүртэлх хувьд нэмэлт ажил гүйцэтгэж болно.

Системийн 1 жилийн баталгаат хугацаа дууссаны дараа захиалагч гүйцэтгэгчтэй үндсэн гэрээний тодорхой хувиар засвар үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж болно.

5. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Төрийн байгууллагын баримт бичгийн удирдлагын үйл ажиллагаа, түүний шат дамжлагын талаар ойлголт мэдлэгтэй байна

- Мэдээлэл технологийн чиглэлээр тэр дундаа RFID Технологи болон үүлэн систем хосолсон программ хангамж нийлүүлэх чиглэлээр сүүлийн 1 жилд дор хаяж 2 төсөл ажил нэвтрүүлсэн байх. Нотлох баримт шаардлагагүй бөгөөд нэгтгэл байдлаар харилцагчдын холбоо барих мэдээллийг илгээхэд болно.
- Гүйцэтгэгч байгууллага нь 2020 оноос хойш үүсгэн байгуулагдсан RFID технологийг тасралтгүй судалж сайжруулалт хийсэн дээрх шаардлагыг хангасан цогц систем нийлүүлэхэд бэлэн байх шаардлагатай.
- Дээрх шаардлагыг хангасан системийн дэлгэцийн зургуудтай хослуулсан шаардлагад бодитой нийцсэн үйл ажиллагаа явуулж буй, шат дараалалтай цэгцтэй, зурган баримт илгээж тендерийн материалд хавсаргсан байх шаардлагатай. Мөн тус баримтад системд хандах холбоосыг тестийн нэвтрэх эрхийн хамтаар илгээсэн байх ёстой.
- Санал болгож буй үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарч болох өөрчлөлттэй дасан зохицож, богино хугацаанд тус шинэчлэлтийг хийх чадвартай байх.
- Төрийн албаны байгууллагад болон төрийн өмчит компанид дор хаяж нэг удаа систем нэвтрүүлсэн туршлагатай байх.
- Хязгаарлагдмал хариуцлагатай Хувийн
- Төрийн албан хаагчдын ажлыг хөнгөвчилсөн, системийн өөрчлөлт шинэчлэлтийн хөгжүүлэлтийн зардлыг бууруулсан “Business Process Automation Platform” дээр суурилсан системтэй байх.
- RFID шошгууд нь олон улсын чанарын шаардлагатай хангасан протоколыг дагаж мөрддөг байхаас гадна, Impinj брендийн M730 чиптэй байх.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн RFID тоног төхөөрөмж үйлдвэрлэгчээс худалдан борлуулах албан ёсны эрхтэй байх.
- Уншигч төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийн 13-р үеийн үйлдлийн системтэй байх, секундэд 900-н таг унших чадалтай байхаас гадна, үйлдвэрийн хүнд нөхцөлд таарсан буюу “rugged” төхөөрөмж байх шаардлагатай.
- Хэвлэгч төхөөрөмж нь системтэй холбогдож, уялдаа холбоотой ажилладаг байх.
- Ирээдүйд СБДНДГ-ийн шаардлагын дагуу нэмэлт сайжруулалт хөгжүүлэлт хийх бусад системтэй холболт хийх боломжтой байх.
- Гүйцэтгэгч байгууллага нь татварын болон нийгмийн даатгалын өр төлбөргүй байх.

6. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Энэхүү системийг нэвтрүүлсэнээр Архивын удирдлагатай холбоотой үйл ажиллагаанууд нь ямар нэгэн чирэгдэл саадгүй мөн гар ажиллагаагүй явагдаж үйл ажиллагааны зардалыг хэмнэх цаашлаад тооллогын ажилд их цаг зарцуулахгүй байхаас гадна архиваас авсан баримт нь хэнд, хаана, хэзээ шилжсэнийг хянах, цахим архивын лавлагааг бодит цагын горимоор хийх боломжтой болох юм. Түүнчлэн, төхөөрөмжүүд нь чанарын шаардлага хангахуйц хүчин чадал сайтай, мөн сайн материалаар хийгдсэн байх шаардлагатай.

7. ТАЙЛАНТ ХУГАЦАА

№	Тайлангийн нэр	Ирүүлэх хугацаа	Формат	Хүлээн авагч
1	BRMN 2.0 Процесс зураглал, диаграм	Гэрээ байгуулснаас хойш 10 хоногт	Файл хэлбэрээр	Гүйцэтгэгч
2	Нэмэлт хөгжүүлэлт хийх, программын тохиргоо хийх	Гэрээ байгуулснаас хойш 20 хоногийн дотор	Онлайн хэлбэрээр	Захиалагч
3	Баримт болон шошгонуудын цахим бүртгэл	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор	Биет хэлбэрээр	Захиалагч
4	Системийг турших, нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, ажил хүлээлцэх.	Гэрээ байгуулснаас хойш 45 хоногийн дотор	Онлайн хэлбэрээр	Захиалагч
5	Жигдрүүлэлт, программын сайжруулалт хийх	Гэрээ байгуулснаас хойш 2 сарын дотор	Онлайн хэлбэрээр	Захиалагч
6	Нэгдсэн системийн гарын авлага	Гэрээ байгуулснаас хойш 2 сарын дотор	Файл хэлбэрээр	Захиалагч
7	Эцсийн тайлан, ажил хүлээлцэх	Гэрээ байгуулснаас хойш 2 сарын дотор	Файл хэлбэрээр	Захиалагч

Тайлбар: Дээрх тайлант хугацаа нь дагалдах үйлчилгээ гүйцэтгэх 2 сарын хугацаанд багтсан болно.